<b>Төсөл хэрэгжүүлэх үед авч хэрэгжүүлэх хөдөлмөр хамгааллын арга хэмжээ</b>									
1	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн барилгын ажлын талбай	Хүн/өдөр			Дотоод төлөвлөлтөөр зохион байгуулах	2023 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн барилгын ажлын талбай	удаа	1	500,000	500,000	2023 он	
		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн барилгын ажлын талбай	-	-	-	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2023 он	

		Барилгын ажилчдын түр суурин бүрийг анхны тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдээр хангах	Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагын ажилчдын хотхон	Жил /удаа	1	1,000,000	1,000,000	2023 он	
2	Ажилчдын хотхоныг зөв зохион байгуулаагүйн улмаас ажилчдын эрүүл мэндэд эрсдэл үүсэх	бие засах өрөө, бусад ариун цэврийн байгууламжыг сар бүр ариутгаж ажиллах	Бүх төрлийн барилгын ажил явагдаж буй талбайнууд, мөн ажилчдын хотхонууд	-	8	215 000	1 720 000	2023 он	“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (МОН3787/3788)” -ийн батлагдсан Байгаль орчны менежментийн ерөнхий төлөвлөгөө
<b>Төслийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нэг жилийн нийт зардал, төгрөг</b>							<b>4,620,000</b>		

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Билгүүн од констракшн” ХХК-ний Хэнтий аймгийн Дадал сумын “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах” төслийн ажлын явцад гарч болох хог хаягдлын эх үүсвэрийг Монгол улс болон олон улсын хууль тогтоомж, стандарт шаардлагын дагуу хянах, бууруулахад чиглэгдэх юм.

Аливаа төслийн үйл ажиллагаанаас үүдэн хог хаягдал үүсгэх нь зайлшгүй бөгөөд холбогдох хууль, журмын дагуу хог хаягдлын менежментийг системийн арга хандлагыг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд төслийн холбогдох стандартуудыг тогтоох, нөлөөлөл бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээ ба аудитын хөтөлбөр зэрэг төслийн хог хаягдлын менежментийн удирдлагуудыг тогтоож өгсөн.

### 9.1 Зорилго

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилгууд нь:

- ✓ Хог хаягдлын менежментийн талаархи дотоодын болон олон улсын хууль, журам, стандартуудыг тодорхойлох;
- ✓ Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох;
- ✓ Үүрэг, хариуцлагуудыг тодорхойлох;
- ✓ Хяналт шинжилгээ/аудит болон тайлагнах журмуудыг тодорхойлох;

### 9.2 Хууль, эрхзүйн орчин

Хог хаягдлыг цуглуулах, ялгах, хадгалах, боловсруулах, зайлуулахтай холбоотой Монгол улсын болон олон улсын дүрэм журам, стандартуудыг заасан болно.



### 9.2.1. Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаас

№	Нэр	Батлагдсан огноо, актын дугаар
<b>Сайдын тушаал</b>		
1	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага	БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт
2	Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал	БОАЖС-ын 2017 оны А/368 дугаар тушаалын хавсралт
3	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам	БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн а/428 дугаар тушаалын хавсралт
4	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралт

### 9.2.2. Стандартууд

#### Монголын улсын стандартууд

- ✓ “Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 5344 - 2011
- ✓ “Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөв” MNS 6342- 2012 5х

#### Олон улсын стандартууд

- ✓ ЕХ-ны хог хаягдлыг ландфил хийх тухай захирамж 99/31/ЕС (1999 он);
- ✓ ЕХ-ны хог хаягдлыг шатаах устгах тухай захирамж 2000/76/ЕС (2000 оны 12 сарын 4- ны өдөр);
- ✓ ДЭМБ-ын Эрүүл мэндийн салбарын аюулгүй хог хаягдлын менежмент: Бодлогын баримт бичиг, бүртгэлийн хуудас № 281, (эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежмент);
- ✓ Аюултай хог хаягдлын хил дамжсан хөдөлгөөний хяналтын тухай конвенци, хог хаягдлыг устгах конвенци (Базелын конвенци, Монгол улс 1997 онд нэгдсэн);
- ✓ US EPA стандартууд CFR 258 (Хотын хатуу хог хаягдлыг ландфилдэх шалгуур) төсөлд хэрэгжүүлэхээр баталсан;

### 9.2.3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт

Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нөлөөлөл бууруулах арга хэмжээ болон менежментийн хяналтыг төслийн ажлын үед хэрэгжүүлнэ. Гэрээт гүйцэтгэгчид нь доорх хүснэгтэнд тодорхойлсон арга хэмжээнүүдийг өөрсдийн ажлын дүрэм журманд тусган дагаж мөрдөнө. Мөн туслан гүйцэтгэгчийн төлөвлөгөөнүүдэд доор дурьдсан шаардлагуудыг дагаж мөрдөхөөр оруулж өгсөн байх ёстой.

“Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг, “энгийн хог хаягдал” гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг, “ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг тус тус хэлнэ.

Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.

#### Энгийн хог хаягдал

Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалж, орон нутагт хамгийн ойр хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт хүргэнэ.

Дахин ашиглах боломжтой хог хаягдалд дараах хог хаягдал хамаарна:

- ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савалгаа/
- ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/
- ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;
- ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;
- ✓ Лааз;
- ✓ Мод, модон эдлэлийн хаягдал;
- ✓ Хувцас, даавуун эдлэл;
- ✓ Савхи, резин;
- ✓ Өвс, мод.

Дахин ашиглах боломжгүй хатуу хог хаягдалд дараах энгийн хог хаягдлууд хамаарч байна.

а/ Хүнсний хог хаягдал. Үүнд:

- ✓ Хоолны үлдэгдэл;
- ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;
- ✓ Хэрэглэсэн хүнсний тос.

б/. Халаалтын болон уурын зуухны үнс:

в/. Бусад хог хаягдалд дараах хог хаягдал орно:

- ✓ Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;
- ✓ Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;
- ✓ Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаас гарах лаваас бусад/;
- ✓ Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;
- ✓ Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал багтана.

Энгийн хог хаягдлыг түр хадгалах цэг нь ангилан ялгах боломжтой, бороо ус орохооргүй, хөрсөнд нэвчихгүй байх шаардлагатай байдаг.

Энгийн хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулах гэрээг байгуулна.

Аюултай хог хаягдал

Оффис, үйлчилгээний газрын үйл ажиллагаанаас төслийн үйл ажиллагаанаас оффисын зориулалтаар ашиглах зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хаягдал буюу ахуйн зориулалтын батерей, принтер, хувилах машины хор зэрэг нь аюултай хог хаягдал болох юм. Иймд эдгээр хог хаягдлыг ахуйн хог хаягдалтай холилгүйгээр тусад хадгалж, эдгээр хаягдлыг хүлээн авах цэгүүдэд нийлүүлэх нь зүйтэй.

Монгол улсад химийн хортой болон аюултай хуванцар хог хаягдлын савыг дахин боловсруулж ашиглах анхны үйлдвэрийг “Цэцүүх трейд” ХХК ашиглалтад оруулсан, ашигласан принтер, хувилах машины хорыг “Электро ВорлдТрейд” ХХК цуглуулан авч, дахин боловсруулж эхлээд байна. Батерей, принтерийн хоронд агуулагдах хүнд металл нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд маш хортой, аюултай хог хаягдлын тоонд ордог. Бидний дунд ашигласан батерейг хазаж, дахин ашиглаж болдог гэсэн ойлголт түгээмэл бий.

Гэхдээ энэ нь хүний эрүүл мэндэд асар их хөнөөлтэй гэдгийг зарим хүмүүс мэддэггүй билээ. Батерей нь асар их хүчтэй хүчил агуулдаг тул ам, хамраа түлэх, улмаар насан туршдаа амт мэдрэхгүй, ярих чадвараа алдаж болох эрсдэлтэй. Мөн төрөл бүрийн хавдар, ургийн гажиг үүсгэх аюултай.

**Хог хаягдлын төрлүүд ба хэмжээ:** Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

**Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ**

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
<b>Энгийн хог хаягдал</b>		
Дахин ашиглах боломжтой	Цаас	Оффисын 1 ажилтан сард 0.2кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 1 хүн/хон*0.6кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 1хүн/хон*0.5
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: <ul style="list-style-type: none"> <li>• Ундааны сав баглаанаас 1 хүн/хон* 0.3кг</li> <li>• Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна</li> </ul>
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	1 хүн хоногт 0.1кг
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	1 хүн хоногт 0.15кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
<b>Аюултай хог хаягдал</b>		
Батарей аккумулятор	Хар тугалгатай батарей	Батарей солих ээлжийн тоогоор гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Техникийн ээлжийн тоогоор гарна. Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.

Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: <ul style="list-style-type: none"> <li>Тос агуулсан арчих материалын хаягдал</li> <li>Тос агуулсан хөрсний хуулдас</li> </ul> Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.
Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

**Хог хаягдлыг зайлуулах, устгах.** “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах, устгах харилцааг зохицуулах зөвлөмжийг төслийн хүрээнд үүсэх хог хаягдлын нэр төрөл бүрээр авч үзэх шаардлагатай болно. Харин үүссэн хог хаягдлын хэмжээ нэр төрлүүдээр бага, холбогдох эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхөд тээврийн ачааллын хангалттай хэмжээнд хүрэхгүй байж болзошгүй тул төслийн хүрээнд үүсэх хог хаягдлыг нэгдсэн менежментэд шилжүүлж болно гэж үзэж байна.

**Хүснэгт 6. Хог хаягдлыг зайлуулах арга хэлбэр**

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
<b>Энгийн хог хаягдал</b>	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар,	
резин,	
металл, төмөр	
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал) Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна. Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
Шингэн хаягдал	Зөвшөөрөгдсөн цэгт түр хадгалан зөвшөөрөгдөн цэгт зайлуулна.

Аюултай хог хаягдал	
Хар тугалгатай батарей	Аюултай хог хаягдлын зөвлөмжийг баримтална. Эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Ашигласан тос, масло	Зөвшөөрөлтэй авто засварын газарт техникийн үйлчилгээ хийгдэнэ.
Хаягдал шингэн катализатор	Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглүүлнэ.
Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

**Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал.** Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг хог хаягдлын нэр төрөл бүрийн менежментийг яаж зохион байгуулснаас хамаарна.

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Ажилчдын хотхон, барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	-	50,000	12	600,000	2023 онд сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Барилгын ажлын талбай зэрэг бүх төрлийн байгууламжууд	-	100,000	12	1,200,000	2023 онд сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
<b>НИЙТ</b>						<b>1,800,000</b>		

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ОХШХ-т төсөл хэрэгжих газрын агаарын чанар, усны чанар, хөрсөн бүрхэвч, дуу чимээний нөлөөлөл зэрэг хяналт шинжилгээний үзүүлэлт, хэмжилт хийх, дээж авах байршил, хугацаа, давтамж, холбогдох стандарт болон эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсвийг тооцоолов.

ОХШХ-ыг байгаль орчны мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж, хяналт тавьж, тухайн бүрт нь тайлагнан ажиллана.

2022 оны БОМТ-нд хог хаягдлын төвлөрсөн цэг болон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах төслийн ажиллах үед авч хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт **6,700,000** мян.төг зарцуулахаар тусгагдсан. Үүний дагуу ОХШХ-ийг боловсруулахдаа лабораторийн шинжилгээний дараах тарифийг үндэслэл болгов.

**Хүснэгт 7. Лабораторийн шинжилгээний тариф**

№	Шинжилгээний төрөл	Үнэ, ₮	Шинжилгээ хийлгэх хугацаа	Итгэмжлэгдсэн лаборатори	
1	Агаарын чанарын шинжилгээ (SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)	25.000	4-р сар	УЦЦОШГ-ын БОХЗТЛ	
	Тоосны үзүүлэлт (PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> , TSP)	25.000			
	Дуу шуугиан	20.000			
2	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	25.000		9-р сар	“Инженер геодези” ХХК
	Хөрсний бохирдлын шинжилгээ (1 дээжинд 6 элемент: Cu, Cr, Cd, Pb, Zn, Ni)	28.000			
	Хөрсний бактерлогийн шинжилгээ	22.000			
3	Ундны усны бүрэн шинжилгээ	46.000	9-р сар	“Монгол ус” ТӨААТҮГ	
	Усны бохирдлын шинжилгээ (1 дээжинд 22 элемент)	68.000			
	Усны бактериологийн үзүүлэлт	46.666			


2023 ОНЫ ОХШХӨТӨЛБӨР

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян, төг	Нийт зардал мян, төг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар орчин	Агаарын чанарын шинжилгээ Нийт тоос Хүхрийн исэл SO <sub>2</sub> , Азотын исэл NO <sub>2</sub> Дуу шуугиан	Төслийн талбайд 4 байршилд	Төслийн талбайд - Салхин доод талд 20-40 м-ийн бүсэд жилд 2 удаа Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн техникчийн хамт гүйцэтгэнэ.	Зөвхөн нийт тоос болон SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> шинжилнэ. 8 дээж * 70 000 = 560 000 Техникчийн томилолт 50 000 төгрөг 1 удаагийн хэмжилт, дээжлэлтийн зардал 610 000 * 2 = 1,220,000	1,220,000	MNS (ISO) 4225:2001 MNS 4585:2007 MNS 3384:1982 MNS 5365:2004 MNS 17.2.316-1988 MNS 3383:1982 MNS5885:2008 MNS (ISO) 5667-4:2001 MNS-4048:88 MNS 6063:2010. MNS 4585:2016), MNS 5919:2008 MNS 5013 :2001 MNS ISO 4221: 2002, MNS 5365:2004
	O <sub>2</sub> , CO <sub>2</sub> , CO, NO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CxHy/HC, H <sub>2</sub> S, утааны хэм °C, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Төслийн ажилд ашиглагдаж байгаа машин техник дизель цахилгаан үүсгүүрүүдийг ялгаруулж буй утаанд нь хэмжилт хийх		15 ш хэмжилт * 58 000 = 870 000*2	1,740,000	
	Тоосны хэмжилт: PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> Тоосны чөлөөт Уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Төслийн талбайд 4 байршилд		Зөвхөн нийт тоос болон PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> шинжилнэ. 8 дээж * 58 000 = 464 000 464 000 * 2 = 928,000	928,000	
Хөрсөн бүрхэвч	Хөрсний өнгөн болон дээд үе	Төслийн талбайд 4 байршилд	Төслийн талбайд Нийт 8 цэг /Жилд 2 удаа, 04, 09 сар/	Нэг удаагийн дээжлэлт: 8 цэг* 78 000 = 624,000*2	1,248,000	MNS 3298:1991 "Хөрснөөс шинжилгээнд



	давхаргын элжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтцын өөрчлөлтийг хянах					дээж авахад тавигдах шаардлага” MNS 3297-91 “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлэлт, үзүүлэлтийн төрөл” MNS 5850:2019 хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Усан орчин</b>	Ca, Mg, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Төслийн хяналтын цооногууд, Балын арын булгаас дээж авах	Жилд 2 удаа буюу 4 болон 9 саруудад дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	Нэг удаагийн дээжлэлт: 3 ш дээж* 160,666 = 482,000*2	964,000	MNS 4586:1998 MNS 4079:1988 MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2001 MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667-10:2001 MNS (ISO) 5667-11:2000 MNS (ISO) 11083:2001 MNS 4047:1988 MNS 2570:1978 MNS 3936:1986 MNS 0900:2005 (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 MNS (ISO) 5667 11:2000 MNS (ISO) 5667-1:2002
<b>Ургамал</b>	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо	Төслийн талбайд 4 байршилд	Жилд 1 удаа 8 сард	(Нийт 4 байршилд хэмжилт судалгаа) 150,000	600,000	Мониторингийн цэг бүрт судалгааг 25х 25 м2 талбайд 1 удаагийн давталттайгаар хийх

	Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1 м <sup>2</sup> /бодгаль Тоосны тархал					
<b>Нийт төсөв</b>					<b>6,700,000</b>	



**Зураг 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн цэгүүдийн байршил**

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх-хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (ISO 14001, 2004).

БОУТ-ны бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

Байгаль орчны бодлого: Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.

Төлөвлөлт: Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;

Хэрэгжүүлэлт: Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц, үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;

Хяналт, сайжруулалт: Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;

Удирдлагын хяналт: Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянана.

“Билгүүн од констракшн” ХХК-ний Хэнтий аймгийн Дадал сумын “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах” төслийн үргэлжлэх явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмын дагуу төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн удирдлага болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал авах зорилгоор тус арга хэмжээнд төсөвлөсөн.

Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	1 жилийн зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь ба давтамж	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4	6
Дадал сум, Баян-Овоо багийн захиргаатай хамтран төсөлд ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэх, тэднээс ажлын шаардлага хангасан иргэдийг ажлын байраар хангах	Турт багийн иргэд	-	2023 онд нэг удаа	Төсөл хэрэгжүүлэх нэгж ба гүйцэтгэгч байгууллага
Сум, баг, тосгоны удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Төслийн явцыг орон нутгийн удирдлагуудад танилцуулаг	1,500,000	2023 онд нэг удаа	Гүйцэтгэгч байгууллага
Дараа жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахад бэлэн болгох	Төслийн талбай	5,600,000	2022 оны сүүлийн улиралд	Гүйцэтгэгч байгууллага
<b>Нийт зардал</b>		<b>7,100,000</b>		

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гүйцэтгэгч байгууллага нь хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар Хэнтий аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газарт хүргүүлэн ажиллана. Мөн бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд нөлөөллийн бүсийн оршин суугчдад хийнэ.

### БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах нэг жилийн зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан ба ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	7	8
Хэнтий аймгийн байгаль орчин, Аялал жуулчлалын газар	БОМТ-ний биелэлтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэн баталгаажуулах (хэвлэмэл болон цахимаар)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 оны 11-р сарын 5-н дотор багтаах	1,000,000	Гүйцэтгэгч байгууллага	Аймгийн төв
Дадал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ИТХ-аар оруулж танилцуулж, санал авах (илтгэл)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 онд 10, 11-р сарын ИТХ-д багтаах	1,000,000	Гүйцэтгэгч байгууллага	Сумын төвд
Багийн засаг дарга, Тосгоны захирагч	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж хүргүүлэн танилцуулж, санал авах (хэвлэмэл болон цахимаар)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 онд 10-р сард багтаах	500,000	Гүйцэтгэгч байгууллага	Багийн төвд
Баргийн иргэдийн нийтийн хурал, Тосгоны иргэдийн нийтийн хурал	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гарган танилцуулж, хэлэлцүүлэн санал авах (илтгэл)	БОМТ-ний биелэлт, хэрэгжилтийн тухай	2023 онд 10-р сард багтаах	1,000,000	Гүйцэтгэгч байгууллага	Багийн төвд
<b>Нийт зардал</b>				<b>3,500,000</b>		

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Урьдчилсан байдлаар тооцож үзэхэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нэг жилд нийт **26 720 000** төгрөг зарцуулах тооцоо гарч байна. Энэхүү хэмжээ нь тухайн жилээс хамааран өөрчлөгдөж болно.

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ	Тайлбар
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2,550,000	
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-	
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	450,000	
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	4,620,000	
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,800,000	
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6,700,000	
Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	7,100,000	
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3,500,000	
<b>Нийт дүн</b>	<b>26 720 000</b>	

Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан энэхүү тайланд төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

- А. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- В. Эрчим хүчний яамны тусгай зөвшөөрлийн хуулбар
- С. Барилга хот байгуулалтын яамны тусгай зөвшөөрлийн хуулбар
- Д. Батлагдсан 3-н жилийн БОМТ-ний нүүр хуудас
- Е. Хэнтий аймгийн Дадал сумын хатуу хог хаягдлын байгууламжийн барилга угсралтын ажлын хуваарийн хуулбар
- Ү. Хяналтын хуудас

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”